



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 54

Мөрөн

Орон нутгийн өмчийн төлөөлөл томилох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “н, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Могойн гол” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд орон нутгийн өмчийн төлөөллийг дараах бүрэлдэхүүнтэй томилж, удирдамжийг хавсралтаар баталсугай.

- Ц.Баттогтох – Аймгийн Орлогч дарга
- Ц.Бэхбаяр - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Н.Болд-Эрдэнэ – Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын мэргэжилтэн
- Ц.Нармандах – Аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогч

2. Орон нутгийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 58 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Гончиг/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

010153

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
04 дүгээр сарын 19 -ны өдрийн 54 дугаар  
тогтоолын хавсралт



**“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН УДИРДАМЖ**

“Могойн гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн анхдугаар хуралд Хөвсгөл аймгийн өмчийн төлөөлөл болон томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах удирдамжийн дагуу оролцоно.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад Ц.Баттогтохыг нэр дэвшүүлж, саналаа өгнө.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_